



НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Ор хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/479 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дунфайнайрамдал ХХК –ний эмнэлэгт өвчний хурц /цочмог/ үеийн эмчилгээний 15 ор, Цу Эрдэнэ ХХК-ний эмнэлэгт өвчний цочмог үеийн 10 ор, уламжлалт эмчилгээний 10 ор, Төр трейд ХХК-ний эмнэлэгт сэргээн засах эмчилгээний 5 ор, Энэрэлт манал ХХК-ний эмнэлэгт уламжлалт эмчилгээний 6 ор, Энх саран ХХК-ний сувилалд сэргээн засах эмчилгээний 45 ор, уламжлалт эмчилгээний 45 ор тус тус хуваарилсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагын батлагдсан орны хязгаарт багтаан үзүүлж буй тусламж, үйлчилгээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/-т даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Б.Одгэрэл/-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500175